

<p><u>Тусгай зөвшөөрөл хүсэгч нь согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэх сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтээ аймаг нийслэлийн ЗДТГ-т доорх материалыг бүрдүүлэн гаргана.</u></p> <p>1. Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл /эрхлэх үйлдвэрлэл, үйлчилгээний төрөл, хугацааг тодорхой дурьдах/;</p> <p>2. Тусгай зөвшөөрөл хүсэгч нь хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ;</p> <p>3. Тусгай зөвшөөрөл хүсэгч нь иргэн бол иргэний үнэмлэхийн хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар;</p> <p>4. улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;</p> <p>5. тухайн үйлдвэрлэл, үйлчилгээний онцлогоос шалтгаалан хуульд заасан бусад баримт бичиг;</p> <p>6. үйл ажиллагаа явуулах барилга байгууламжийн гаднах орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор дүрс бичлэгийн техник, хэрэгсэл суурилуулж, энэ талаар цагдаагийн байгууллагын саналыг авсан байх;</p> <p>7. Тухайн орон нутагт үйлдвэр байгуулах эдийн засгийн үндэслэл, үр ашгийн тооцоо, бүтээгдэхүүн экспортлох нөхцөл, зургийн даалгавар</p> <p>8. Зах зээлд өрсөлдөх чадвартай шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд чиглэсэн дэвшилтэт технологи, тоног төхөөрөмжийн танилцуулга</p> <p>9. Исгэлтийн үйлдвэрлэлийн технологич, мэргэшсэн ажилчдын бүртгэл Үйлдвэрийн дотоод дүрэм, технологийн заавар, хөдөлмөр хамгаалал, галын аюулгүй байдлыг хангах дүрмийн төсөл</p> <p>10. Үйлдвэрлэл явуулах байрны зураг төсөл нь барилга, эрүүл ахуй, техникийн болон галын аюулгүй байдлын стандарт шаардлагад нийцсэн эсэх талаар МХБ-ын санал дүгнэлт</p> <p>11. Түүхий эд бүтээгдэхүүний чанарт физик, хими, микробиологийн иж бүрэн шинжилгээ хийх лаборатори байгуулах шаардлагыг тусгасан танилцуулга</p> <p>12. Стандартын дагуу боловсруулж, эрүүл мэндийн анхааруулгыг тусгасан шошгоны загвар, баталгаажуулсан барааны тэмдэг</p> <p>13. Согтууруулах ундааны үйлдвэрийн технологийн шугамд техникийн тодорхойлолтын үзүүлэлт хангасан тоолуур суурилуулах нөхцөлийг тусгасан баримт</p> <p>Аж ахуйн нэгж, байгууллагууд нь дээрх бичиг баримтуудыг бүрдүүлэн аймаг нийслэлийн ЗДТГ-т хүсэлтээ гаргана.</p>	<p>Аймаг нийслэлийн ЗДТГ нь хүсэлт төслийг хүлээн авч Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын санал, МХБ-ын дүгнэлтийн хамт хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлснээр ажлын хэсэг томилогдон тусгай зөвшөөрөл олгох асуудлыг шийдвэрлэнэ.</p>
---	--